

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН МЭДЭЭ

Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар:

Хөвсгөл аймагт төрийн албаны ерөнхий шалгалт 11 дүгээр сард амжилттай зохион байгуулж дууслаа.

Энэ удаагийн шалгалтад 359 иргэн бүртгэгдэж, 294 иргэн шалгалтад орж, 102 иргэн шалгалтад тэнцэж, төрийн жинхэнэ албаны нөөцөд бүртгэгдэх боломжтой боллоо.

Багийн Засаг дарга нарын манлайлал, ёс зүйг дээшлүүлж, хууль тогтоомжийн хэрэгжилт, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, ажлын уялдаа холбоог хангах, “Багийн хөгжлийг дэмжих төлөвлөгөө-3”-ыг танилцуулах зорилгоор 2021 оны 11 дүгээр сарын 22-24-ны өдрүүдэд аймгийн Засаг даргын Тамгын газрын “Соёмбо танхим”-д аймгийн ИТХ, АЗДТГ, Статистикийн хэлтэс, Тогтвортой амьжиргаа 3 төсөлтэй хамтран Төрийн захиргааны удирдлагын хэлтэс ерөнхий зохион байгуулалтыг ханган “Багийн Засаг дарга нарыг чадавхжуулах” сургалтыг амжилттай зохион байгууллаа.

Сургалтад аймгийн хэмжээний 129 багийн Засаг дарга, Мөрөн сумын 14 багийн баг зохион байгуулагч нарт оролцов. Эдгээр 129 багаас анх удаа сонгогдсон 68 багийн Засаг дарга байв.

Хоёр. Эдийн засаг, төсөв, санхүүгийн бодлогын хүрээнд:

Төрийн сангийн төлбөр тооцооны программаар 2021 оны 11-р сард 81 Төсөвт байгууллагын үндсэн болон нэмэлт санхүүжилтийн данснаас 10.5 тэрбум төгрөгний **2283** ширхэг гүйлгээ шивэгдсэн байна.

Төсвийн гүйцэтгэлийн 2021 оны 10-р сарын мэдээгээр Орон нутгийн орлого, санхүүжилт 23,732.2 сая төгрөгний төлөвлөгөөтэйгээс 27,443.4 сая төгрөг буюу 115.6 хувийн гүйцэтгэлтэй байна.

Төсвийн гүйцэтгэл 2021 оны 10-р сарын мэдээгээр Орон нутгийн болон тусгай шилжүүлгийн байгууллагуудын төсвийн зарлагын гүйцэтгэл батлагдсан төсөв 129,821.1 сая төгрөг байгаа бөгөөд үүнээс 45,152.3 сая төгрөг нь улсын төсвөөс санхүүжих, 58,293.5 сая төгрөг нь тусгай зориулалтын шилжүүлгээс, 15,641.6 сая төгрөг нь орон нутгийн байгууллагуудад олгох санхүү дэмжлэг болон аймаг сумын орлогоос, 4,082.0 сая төгрөг нь төсөвт байгууллагын өөрийн орлогоос, 6,651.7 сая төгрөг нь орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн төсвөөс тус тус санхүүжигдсэн байна. Төсвийн гүйцэтгэлийн мэдээнд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр 129,821.1 сая төгрөг, зарлагын гүйцэтгэл 118,916.1 сая төгрөг буюу 91.6 % хувьтай байна. ТЗШ-ын санхүүжилт болон санхүүгийн дэмжлэг бүрэн ирсэн. ОНХС-ийн санхүүжилт энэ сард дутуу ирсэн.

Төсвийн гүйцэтгэлийн мэдээгээр Төсвийн нийт авлага **4,625.5** сая төгрөг өмнөх сараас **164.7** мянган төгрөгөөр буурсан.

Нийт өглөг **1,190.6** сая төгрөг өмнөх сараас **15.2** сая төгрөгөөр буурсан байна.

2021 оны 11 дүгээр сарын байдлаар нийгмийн даатгалын санд шимтгэлийн орлого 2535.8 сая төгрөг, сайн дурын даатгуулагчаас 275.5 сая төгрөгийн, шимтгэлийн орлого нийт 2811.3 сая төгрөг буюу 103 хувиар биелүүлсэн.

Төлөвлөгөөг сан тус бүрээр харуулбал:

Төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
Тэтгэвэр	2400.9	2468.6	102.8
Тэтгэмж	200.4	210.1	104.8
ҮОМШӨ	87.8	90.1	102.6
ЭМД	0,0	0,0	0,0
ажилгүйдэл	40.3	42.5	105.5
дүн	2729.4	2811.3	103

Тэтгэврийн даатгалын сангаас 20680 тэтгэвэр авагчид 7628.5 сая төгрөгийн 4 төрлийн тэтгэвэр, тэтгэмжийн даатгалын сангаас 294 даатгуулагчдад 340 сая төгрөгийн тэтгэмжийн зардал, ажилгүйдлийн даатгалын сангаас 97 даатгуулагчдад 63.1 сая төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмж олгосон байна. Нийгмийн даатгалын шимтгэлийн авлага 1161.7 сая төгрөг байна.

Манай байгууллага аймгийн Засаг даргын тамгын газраас “Иргэдээ сонсох” нэрлэсэн жилийн ажлын хүрээнд 2021 оны “Засаглал, эрсдэлийн удирдлагыг эрчимжүүлэ” нэрлэсэн жил болгон зарлаж, байгууллагын хэмжээнд авч хэрэгжүүлэх болон цаг үеийн байдалтай холбоотой нийт 8 дэд төлөвлөгөөг хэрэгжүүлэн тухай бүр холбогдох байгууллагад нь тайлагнан ажиллаж байна

Мөн төсвийн ерөнхийлөн захирагчийн дэргэдэх орон тооны бус дотоод аудитын нэгж, сумдын Засаг дарга нартай хамтран ажиллах гэрээ байгуулан дотоод аудитын нэгжийн тайлан мэдээг сар бүр авч дүгнэн ажиллаж байна.

2021 оны 11 дүгээр сарын байдлаар төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтын дагуу нийт 75 байгууллагад хийж 2021 оны төлөвлөгөөний биелэлт 40 хувьтай байгаа бөгөөд одоо Цагааннуур, Улаан-Уул сумдад санхүүгийн хяналт шалгалт хийсэн байна.

Байгууллагын хэмжээнд 2021 оны 11-р сарын 20-ны байдлаар 292 албан бичиг хүлээн авч, хариутай албан бичгийн хариуг хугацаанд нь хүргүүлж, 283 албан бичгийг холбогдох байгууллагад хүргүүлэн ажиллаа.

Гурав. Хууль эрхзүйн бодлогын хүрээнд :

Хүнсний аюулгүй байдлын чиглэлээр :

Хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээний үе шатанд үүсч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлж, хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг хангуулах зорилтын хүрээнд Хөвсгөл аймгийн хэмжээнд 2500 объектод эрсдэлийн үнэлгээг аймгийн МХГ-аас хийлээ.

“Шинэ жилийн баяр”, “Цагаан сар”, -ыг угтан МХЕГазрын даргын баталсан удирдамжийн дагуу давхардсан тоогоор нийт 26 хүнсний үйлдвэр, цех, 38 хоолны газар, 56 худалдааны газрын түүхий эд, бүтээгдэхүүний чанар стандарт, хадгалалт, хамгаалалт, гарал үүсэл, баталгаажилт, хоол, хүнс үйлдвэрлэлийн технологи ажиллагаа, халдвар хамгааллын дэглэмийн мөрдөлтийн байдалд урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг хийж ажиллаж байна.

Шалгалтаар нийт 312 зөрчлийг илрүүлж, 264 буюу 84.3 хувийг газар дээр нь арилгуулж, 2 цех, 3 худалдааны газарт хугацаатай албан шаардлага өгч, биелэлтийг хангуулан зөрчлийг арилгуулж ажиллалаа. Шалгалтын явцад бууз, банш, хиам, зайдас, хэвийн боов, шанзтай еэвэн зэрэг нийт 21 нэрийн бүтээгдэхүүнээс 32 дээж авч лабораторийн шинжилгээнд хамруулан, хадгалалтын хугацаа дууссан, чанар аюулгүй байдлын шаардлага хангахгүй 16 нэрийн 10.5 кг, 72 ширхэг, 1500000 төгрөгийн бүтээгдэхүүнийг хураан авч, устгуулахаар аймгийн Засаг даргын зөвлөлд шилжүүлээ.

Байгаль орчны хяналтын чиглэлээр :

Хөвсгөл аймгийн Эрдэнэбулган суманд үүссэн шар усны үеийн асуудлаар тус суманд байгаль орчны хяналтын улсын байцаагч Б.Даваасүрэн, Эрүүл ахуйн хяналтын улсын байцаагч Л.Нямгэрэл нар байгаль орчны бохирдол, орчны эрүүл ахуйн чиглэлээр газар дээр нь хяналт тавин ажиллаж тус сумын хогийн цэгийн нөхцөл байдалд дүгнэлт гаргаж хөрс, усны дээжээс шинжилгээ авч дүгнэлт гарган ажиллаж байна.

Геологи уул уурхай, Байгаль орчин, Авто замын хяналтаар:

Хөвсгөл аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэгт геологи уул уурхайн хяналтын улсын байцаагч, байгаль орчны хяналтын улсын байцаагч, Авто замын хяналтын улсын байцаагч нар тус тус орж Могойн гол ХК-аас тээвэрлэгдэж байгаа нүүрс тээврийн үйл ажиллагаатай газар дээр нь танилцаж Могойн гол, Мөрөн, Мөрөн- Эрдэнэт чиглэлийн улсын чанартай авто зам, Дэлгэрмөрөн голын хилэнтийн гүүрэнд даац хэтрүүлсэн тээврийн хэрэгслийн

тээвэрлэлтээс үүсэх аюул эрсдэлийг тооцоолж аймгийн засаг даргад улсын байцаагчийн зөвлөмжийг хүргүүлсэн.

Эрсдэлийн үнэлгээ:

Мэргэжлийн хяналтын газар 2021 оны эрсдэлийн үнэлгээг хяналтын 24 чиглэлээр 6303 объектод хийж, их эрсдэлтэй 2460, дунд эрсдэлтэй-2003 бага эрсдэлтэй-1840 тус тус үнэлэгдсэн байна.

Онцгой байдлын чиглэлээр:

Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын Хатгал тосгоны Хөвсгөл нууранд живсэн "Сүхбаатар" хөлөг онгоцыг татан гаргах ажиллагаанд Онцгой байдлын газраас 46 алба хаагч оролцсон. Тус ажиллагаанд мэргэжлийн өндөр ур чадвар гарган ажилласан 19 алба хаагчид Монгол Улсын Төрийн дээд одон цэргийн гавьяаны улаан тугийн одон, Цэргийн гавьяаны одон, Цэргийн хүндэт медаль, Шударга журам медалиар тус тус шагнагдсан. Мөн 28 алба хаагч Батлан хамгаалах яамны шагнал Дайчин алдар-3, Эх орны төлөө-3 дугаар зэргийн медалиар шагнагдсан байна.

Онцгой байдлын ерөнхий газар, АНУ-ын Элчин сайдын яам, Иргэний цэргийн харилцааны дэмжлэгийн багтай хамтарсан эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх сургалтад Эрэн хайх, аврах салбарын бие бүрэлдэхүүн хамрагдаж мэргэжлийн ур чадвараа дээшлүүлсэн.

МУ-ын Шадар Сайд, аймгийн Засаг дарга, аймгийн Онцгой комиссын 27 дугаар хуралдаанаас гарсан шийдвэрийн дагуу шүлхий өвчний голомттой Төмөрбулаг, Шинэ-Идэр, Галт зэрэг сумдад 2021 оны 12 дугаар сарын 18-ний өдрөөс 2021 оны 12 дугаар сарын 25-ны өдрийг дуустал 8 хоногийн хугацаатай ажиллаа.

Ажлын хэсэг тус сумдын Онцгой комиссыг хуралдуулж авч хэрэгжүүлж байгаа ажилтай танилцаж холбогдох үүрэг даалгаврыг өгч ажилласан байна. Мөн суурин болон хөдөлгөөнт постуудын үйл ажиллагааг газар дээр нь шалгаж холбогдох зөвлөмжийг өгч ажилласан.

Гамшгаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ, сургалт сурталчилгаа

Хөвсгөл аймгийн Эрдэнэбулган сумын Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 1/452 дугаар албан бичгийн хүрээнд тус сумын 4 дүгээр багийн нутагт Эгийн голын халиа /шар ус/ урсаж сумын төвийн 10 өрх, Чичин багийн 3 өрхийн өвөлжөө хашаа, гэр орон өртсөн талаар мэдээллийн дагуу аймгийн Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн А/661 дүгээр захирамжаар аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штаб, Онцгой байдлын газар, Мэргэжлийн хяналтын газар, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Хөвсгөл АЗЗА ТӨҮГ, Орхон аймгийн Зэвсэгт хүчний 180 дугаар ангийн хамтарсан ажлын хэсэг тус суманд ажиллаж нөхцөл байдалтай танилцав.

Одоогийн байдлаар сумын хэмжээнд нийт 33 өрх халианд өртсөн ба хүн ам 168, үүнээс том хүн 94, хүүхэд 74 байна.

Халианд өртсөн 4 дүгээр багийн 3 дугаар хорооны 21 өрхийн эд хогшлыг нүүлгэн шилжүүлж сумын Засаг даргын Тамгын газрын амрах байранд 1, Эрүүл мэндийн төвийн хуучин эмнэлгийн байранд 1, Ерөнхий боловсролын сургуулийн хуучин хичээлийн байранд 1, Халуун усны газрын алжаал тайлах өрөөнд 1 байранд нийт 4 өрхийг тус тус нүүлгэн шилжүүлж түр байрлуулаад байна. Бусад айл өрхүүд хамаатан садан, ах дүүгийнхээ байранд амьдарч байна.

Шалгалтад “Тэвхэн” “Үжин пресс” “Mongolian Outlet”, “Нэмэн” “14-р байр 2-р орц, Хоймор.мн, “Далай ээж” ТВ зэрэг 15-н байгууллага хамрагдсанаас гал түймэр, гамшиг ослын аюулд хүргэж болзошгүй зөрчлийг илрүүлэн арилгуулахаар хугацаат үүрэг даалгавар, Гал түймрийн улсын хяналтын байцаагчийн Мэдэгдэл-10-ыг бичиж тухайн байгууллагад хүргүүлэн, хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгуулах талаар зөвлөн туслах арга хэмжээг зохион явуулан сургалт заавар зөвлөгөө өгч ажиллав.

Хяналт шалгалтын явцад нийт-34 зөрчил илрүүлэн газар дээр нь 10 зөрчлийг арилгуулж, Гал түймрийн улсын хяналтын байцаагчийн мэдэгдэл бичиж 10 үйлчилгээний газар хүргүүлэн ажиллав. Гүйцэтгэлийн хяналт шалгалт явуулахад мэдэгдлийн хариу ирүүлсэн 9 үйлчилгээний газрын 19 зөрчил дутагдал арилгаж хугацаандаа хариу ирүүлээгүй 1 үйлчилгээний газрын 5 зөрчил дутагдлаа арилгаагүй 1 иргэнийг 100000 нэгжээр торгуулийн арга хэмжээ авч ажиллав

Гэмт хэрэг, эрх зүйн сургалт сурталчилгааны чиглэлээр:

Хөвсгөл аймаг дахь Цагдаагийн газар нь 2020 онд гэмт хэргийн шинжтэй 575 гомдол мэдээллийг хүлээн аван шалгасан бол 2021 онд гэмт хэргийн шинжтэй 672 гомдол мэдээлэл бүртгэгдсэн байна. Мөн 2020 онд зөрчлийн шинжтэй 21445 гомдол мэдээлэл хүлээн аван шалгасан бол 2021 онд 22285 гомдол мэдээлэл бүртгэгдэн шалгагдсан байна.

Төрийн алба хаагчдаас 2020 онд 17 төрийн алба хаагч гэмт хэрэг үйлдэн шүүхээр ял шийтгэгдсэн бол 2021 онд 16 албан хаагч ял шийтгүүлсэн байна. Мөн 2020 онд төрийн алба хаагчдаас 148 алба хаагч зөрчлийн хуулиар арга хэмжээ тооцуулагдсан бол 2021 онд 137 алба хаагч арга хэмжээ авагдсан байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх томоохон ажил, арга хэмжээний талаар

Цагдаагийн байгууллагаас улсын хэмжээнд “ЭКО-2021”, “Нөхөн сэргээлт 2021”, “Мотоцикл”, “Авто зогсоол”, “Хүүхдэд ээлтэй жолооч”, “Би...байна”, “Мөрөөдлийн шүхэр”, “Хүүхэд хамгаалал”, “Хичээл эхэллээ”, Сэрэмжилье болгоомжилъё”, “Хичээл эхэллээ”, “Ирээдүйгээ хамгаалъя”, “Мал мах-2021”, “Галт зэвсэг-2021”, “Илрүүлэлт-Оргодол-2021”, “Нуугдмал-2021” арга хэмжээг зохин байгуулахаар төлөвлөгөөг ирүүлсний дагуу дээрх арга хэмжээг орон нутагт зохион байгуулан тайлан мэдээг хугацаанд нь хүргэж ажилласан.

Тус Цагдаагийн газраас санаачлан тодорхой төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор Хөвсгөл аймгийн хэмжээнд “Хүүхэд хамгааллын явуулын

үйлчилгээ”, “Замын тэмдэг тэмдэглэгээ”, “Тусгай дуут дохио”, “Хяналт”, “Бяцхан зорчигчийн аюулгүй байдал”, “Хариуцлага нэмэгдүүлье-Хамтдаа хамгаалъя”, “Хулгай”, “Хамтдаа сэргийлье”, “Хүчирхийллийн эсрэг дуу хоолой”, “Аав”, “Архигүй хөл хорио”, “Байгаль”, “Хүүхэд хяналт”, “Хаалганы цаана”, “Миний гэр миний гудамж”, хэсэгчилсэн арга хэмжээг тус тус зохион байгуулан үр дүнг тооцон ажиллалаа.

Дөрөв. Боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд:

ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ЧИГЛЭЛЭЭР

12 дугаар сард 7 үйл ажиллагаа, үйлчилгээ, сургалт, нөлөөллийн ажилд 322 хүүхэд, 153 залуучууд, 190 насанд хүрэгч, 36 гэр бүл хамрагдсан байна.

ГБХЗХГ-ын фейсбүүк хуудсаар дамжуулан 22 мэдээ мэдээлэл, 2 төрлийн зөвлөмжийг цахимаар хүргэж нийт 411 хандалт авсан байна. Үүний үр дүнд:

Цэцэрлэг сумын ЕБС-ийн хүүхдүүдэд ганцаарчилсан болон бүлгийн сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээг үзүүлж, ганцаарчилсан зөвлөгөө авсан хүүхдүүдийн оношилгооны үр дүн дээр тулгуурлан цаашид хүүхэдтэй хэрхэн яаж ажиллах, тэдэнд ямар асуудал тулгамдаж байсан талаар сургуулийн нийгмийн ажилтанд мэдэгдэж, зөвлөгөө зөвлөмжийг хүргүүлсэн.

“Боловсрол тулганы 3” хөтөлбөрийг дүгнэж, үр дүнг үнэлж шилдэг бүс, сургууль, нийгмийн ажилтныг шалгаруулав.

Аймгийн 2021 оны онцлох гэр бүл, хүүхэд, залуучуудыг шалгаруулж онцлох 13 хүүхэд, 6 гэр бүл, 4 залуу, 1 төрийн бус байгууллагад шагнал гардууллаа.

Аймгийн залуучуудын эвлэлийн байгууллагад ажиллаж байсан үе үеийн ахмад гишүүдийн санал бодлыг сонсож, туршлагаас нь хуваалцсан байна.

Худалдаа үйлчилгээний төв, дэлгүүрүүдэд хүүхдийн эрхийн улсын байцаагчийн зөвлөмж, зурагт хуудсыг түгээн хяналт тавьж ажилласан байна.

Нэг цэгийн үйлчилгээний төвөөр 2021 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн байдлаар нийт 53 хүн үйлчлүүлсэн. Үүнээс хүүхэд 16 (эрэгтэй 3, эмэгтэй 13), насанд хүрэгч 37 (эрэгтэй 14, эмэгтэй 23) байна.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР

"Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар сайжруулах, Тогтвортой хөгжлийн зорилтод хүрэх, эх нярай, хүүхдийн эндэгдэл бууруулах" төсөл Хөвсгөл аймагт ДЭМБ-ын дэмжлэгтэйгээр хэрэгжихээр болсон.

Төсөл хэрэгжих 3 жилийн хугацаанд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний төслийг боловсруулж холбогдох эмч мэргэжилтнүүдээр хэлэлцүүлээ.

2021 оны 12 сард аймгийн эрүүл мэндийн салбарын хүний нөөц хариуцсан ажилтнуудад "Эрүүл мэндийн салбарын ажилтны нэгдсэн бүртгэлийн сан" программын сургалтыг зохион байгуулж, сургалтад ЭМГ, Нэгдсэн эмнэлэг, сум өрхийн эрүүл мэндийн төвүүдээс нийт 42 хүний нөөцийн менежер, ахлах сувилагч нар хамрагдав.

Сургалтыг Эрүүл мэндийн хөгжлийн төв, “Дижитал медик” ХХК-тай хамтран зохион байгууллаа.

Сумдын Эрүүл мэндийн төвийн ахлах сувилагч нарт "Сувилахуйн тусламж үйлчилгээг сайжруулах" нь сэдэвт сургалтыг зохион байгуулж, нийт сум өрх, аймгийн Нэгдсэн эмнэлгийн 60 сувилахуйн удирдлагууд хамрагдсан байна.

БОЛОВСРОЛЫН ЧИГЛЭЛЭЭР

2021 оны 12 дугаар сард Ерөнхий боловсролын сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгч, нягтлан бодогч нарын нэгдсэн уулзалт, сургалт мэдээлэл өгөх үйл ажиллагааг зохион байгуулж нийт 130 гаруй хүн оролцсон бөгөөд Боловсролын тухай хуулийн өөрчлөлт, эрх зүйн шинэчлэл, Цахим төсөв-2022, Боловсролын салбар дахь хүүхэд хамгаалал, анхаарах асуудал сэдвээр мэдээлэл өгч харилцан санал солилцлоо.

Ерөнхий боловсролын сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгч нарын сургалт явагдлаа. Үүнд 77 удирдах ажилтан хамрагдсан.

Боловсролын газар, Титэм ЕБС-ийн гадаад хэлний ЗАН-ийн багш нартай хамтран “Гадаад хэлний сургалтын заах аргазүйг сайжруулах, цахим болон танхимын сургалтад шинэ технологийг /Nearpod платформ/ нэвтрүүлж хэрэглээнд оруулах нь” сэдэвт сургалтыг Их уул суманд Сэлэнгэ бүсийн багш нарыг хамруулан зохион байгууллаа.

"Боловсрол-Тулгын 3" хүүхдийн хөгжил хамгааллын хөтөлбөрийн хүрээнд "Анги удирдагч багш хөгжлийн хөтөч" илтгэлийн уралдаанд 16 сургуулийн 18 багшийн бүтээл ирж 2-р шатанд 9 илтгэлийг хэлэлцүүлж, шалгаруулах үйл ажиллагааг онлайнаар зохион байгууллаа.

Сургуульд хамрагдалтыг дэмжих зөвлөлийн хурлыг онлайнаар зохион байгуулж 2021-2022 оны хичээлийн жилд сургуульд шинээр элссэн тусгай дэмжлэг шаардлагатай хүүхдүүдийг боловсролын үйлчилгээнд хамруулах асуудлыг хэлэлцлээ.

“Хүрэхүй” хөтөлбөрийг аймгийн Боловсролын газар, ГБХЗХГ, Цагдаагийн газар, Хөгжимт драмын театр, “Түмний телевиз”-тэй хамтран зохион байгууллаа. Тус хөтөлбөрийн хүрээнд бүтээсэн 10 цуврал модуль сургалтыг контент байдлаар бэлтгэн ЕБС-ийн 236 бүлгийн 7405 сурагч, 6685 эцэг, эх, асран хамгаалч, 244 анги удирдагч багш нарт хүргэв.

Боловсролын багц хуулийн төслийн хэлэлцүүлэг Дархан-Уул аймагт болж, хэлэлцүүлэгт Дархан Уул, Орхон, Сэлэнгэ, Булган, Хөвсгөл аймгуудаас нийт 400 гаруй төлөөлөгч хүрэлцэн ирсэн. Хөвсгөл аймгаас ерөнхий боловсролын сургууль цэцэрлэгийн багш, захирал, эрхлэгчийн төлөөлөл 22 хүн оролцлоо. Боловсролын байгууллагын ёс зүйн зөвлөлүүдийг чадавхжуулах сургалт 2021 оны 12 сарын 13-ны өдөр БГ-дээр зохион байгуулагдав.

"Хичээл, сургалтын үр дүнг үнэлэх шалгуурыг хэрэглэх арга зүй, аргачлалыг таниулах сургагч багш бэлтгэх" вакум сургалтыг Улаанбаатар хотод, зохион

байгуулж, сургалтад БГ-ын бага боловсрол, математик, мэдээллийн технологи, монгол хэл, гадаад хэл, ТНУ-ы боловсрол хариуцсан мэргэжилтнүүд оролцлоо.

Засгийн газрын 2021 оны 18 дугаар тогтоолоор батлагдсан “Ерөнхий боловсролын сургуулиудыг хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд үе шаттай хэрэгжүүлэх төлөвлөгөө”-ний 2.4-т тусгагдсаны дагуу БШУЯ-наас сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний ажилтнуудыг чадавхжуулах 2 дахь удаагийн сургалтыг цахим хэлбэрээр зохион байгуулагдсан.

2021 онд хүүхдийн хөгжил хамгааллын чиглэлээр хэрэгжүүлсэн “Боловсрол-Тулгын 3” хөтөлбөрийн үр дүнг үнэлэх, “Хөгжлийн хөтөч нийгмийн ажилтан” үйл ажиллагааг зохион байгуулав. Тус үйл ажиллагаан нийт 34 сургуулийн нийгмийн ажилтнууд хамрагдав.

Боловсрол, шинжлэх ухааны сайдын “Шалгуур үзүүлэлт батлах тухай” 2021 оны А/180 дугаар тушаалаах Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн хичээл, сургалтын үр дүнг үнэлэх шалгуурыг баталж, 2021-2022 оны хичээлийн жилд дагаж мөрдөж байгаатай холбогдуулан шалгуурыг хэрэглэх арга зүй, аргачлал, хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх сургалтыг БШУЯ, БҮТ-өөс цахим хэлбэрээр зохион байгууллаа.

Боловсрол, шинжлэх ухааны яам, Дэлхийн Зөн Монгол олон улсын байгууллагатай хамтран “Эерэг хүмүүжлийн арга” үндэсний сургагч багш бэлтгэх сургалтыг үе шаттай зохион байгуулж байна. Орон нутгийн сургагч багш бэлтгэх II шатны сургалтыг БШУЯ-наас гаргасан нэгдсэн хуваарийн дагуу Хөвсгөл аймагт зохион байгууллаа.

СОЁЛ, СПОРТЫН БОДЛОГЫН ЧИГЛЭЛЭЭР

Улсын аварга шалгаруулах тэмцээнд спортын 3 төрлөөр нийт 25 тамирчин, аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг спортын 8 төрлөөр зохион байгуулж нийт 2182 тамирчин оролцлоо.

Монгол Улсын засгийн газрын 05 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Иргэдийн бие бялдрыг чийрэгжүүлэх, хөдөлгөөний хомсдолоос урьдчилан сэргийлж, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, Монгол Улсад шинээр хөгжиж байгаа Софт волейболын спортыг сурталчилан таниулах ахмад тамирчдыг алдаршуулах зорилгоор 2021 оны 12 дугаар сарын 11-12 нд сургалт мэдээлэл, өдөрлөгийн нэгдсэн арга хэмжээ зохион байгууллаа.

Аймгийн Засаг даргын А/617-дугаар захирамжаар Түүх соёлын үл хөдлөх дурсгалын улсын тооллогыг аймгийн хэмжээнд зохион байгуулах ажлын хэсгийг 5 хүний бүрэлдхүүнтэйгээр байгуулж тооллогын ажлыг 2021 оны 12 сарын 12-ны өдөр эхлүүллээ. Монгол Улсын Засгийн газрын 13-р тогтоолоор батлагдсан Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалтад багтдаг “Зуна голын буган чулуун хөшөө цогцолбор”-ыг тооллоо.

Түүх соёлын үл хөдлөх дурсгалыг тоолох аймгийн комисс 2021 оны 12 сарын 13-ны өдөр Шинэ-Идэр суманд ажиллаж Боловсрол соёл, шинжлэх ухааны спортын сайдын А/161 дугаар тушаалаар аймгийн хамгаалалтад байх Дөрөлжийн амны буган

чулуун хөшөө, Цохиотын овооны буган чулуун цогцолборыг тооллоо. Тооллогын комисс Шинэ-Идэр сумаас Зөөлөнгийн Жаргалантын хадны зураг, Нарийний жагаан булаг хадны зургийг шинээр бүртгэн баримтжууллаа. Түүх соёлын үл хөдлөх дурсгалыг тоолох аймгийн комисс 2021 оны 12 сарын 14-16-ны өдөр Галт суманд ажиллаж Монгол Улсын Засгийн газрын 13-р тогтоолоор Улсын хамгаалалтад орших Бартад бригадын буган чулуун хөшөө цогцолбор, Боловсрол соёл, шинжлэх ухааны спортын сайдын А/161 дугаар тушаалаар аймгийн хамгаалалтад байх Их хужирт, доод хужиртын амны хадны зураг, Зүүн хөөнгийн буган чулуун цогцолбор, Нүхтийн амны буган чулуун хөшөө, Өндөр толгойн хадны зураг, Улаан чулууны хадны зураг, Хужиртын хүрээний чулуун суваргыг тооллоо. Мөн Галт сумын Зүрх багт орших Саглагарын агуйн зосоор бичсэн маанийн бичиг, дүрс тэмдэгийг шинээр илрүүлснийг үзэж бүртгэлээ.

Түүх соёлын үл хөдлөх дурсгалыг тоолох аймгийн комисс 2021 оны 12 сарын 17-18-ны өдөр Жаргалант суманд ажиллаж Боловсрол соёл, шинжлэх ухааны спортын сайдын А/161 дугаар тушаалаар аймгийн хамгаалалтад байх Агьтын голын хадны зураг, Гэлэнхүүгийн суварга, Жаргалантын дуган, Арын хүрээний туурийг тооллогод хамрууллаа.

ХӨДӨЛМӨР ХАЛАМЖИЙН ЧИГЛЭЛЭЭР

Жилийн эцсийн өссөн дүнгээр 1165 байнгын шинэ ажлын байр бий болсон байна.

Хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл мэдээллийн нэгдсэн системд ажил идвэхтэй хайж байгаа нийт 1041 иргэнийг бүртгэж ажилласан байна.

2021 оны 12 сарын 31-ны өдрийн байдлаар /өссөн дүнгээр/ 700 иргэн түр болон байнгын ажлын байранд зуучиллаа.

Мөрөн сумын Засаг даргын Тамгын газраас 26 дэлгүүрийн худалдагчийг мэргэшүүлэн мэргэжлийн үнэмлэхтэй болгож, ажлын байрыг нь хадгалж үлдээх хүсэлт ирүүлсний дагуу худалдагчийн түр сургалтыг “Агаар мандал орчин” сургалтын байгууллагатай хамтран зохион байгуулсан. Сургалтад ажилгүйдэлд өртөж болзошгүй 26 иргэн хамрагдаж мэргэжлийн үнэмлэхтэй болсон.

Мөрөн суманд оёдлын үйлдвэр байгуулагдах гэж байгаатай холбогдуулан тус үйлдвэрт ажиллах 45 иргэнд оёдолчны сургалтыг зохион байгуулсан.Тус үйлдвэрийн 110,0 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг УИХ-ын гишүүн Л.Энх-Амгаланы санаачлагаар нийлүүлсэн бөгөөд оёдлын үйлдвэрийн байрыг Мөрөн сумын Засаг даргын Тамгын газраас шийдвэрлэсэн. Сургалтад хамрагдсан 45 иргэнд оёдолчны мэргэжлийн үнэмлэх олгон ажлын байранд зуучилж ажилласан.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.3,12-р зүйлийн 12.1, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2021оны 1-р тогтоолоор батлагдсан “Цар тахалын үед аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх хөтөөлбөр”-ийн 3.2.3, 5.3м дахь заалтын дагуу хөтөлбөрт хамрагдсан малчдад мал маллагааны чиглэлээр туршлага судлах, мэргэжил, арга зүйгээр дэмжлэг үзүүлэх цахим сургалт-хэлэлцүүлгийг “Өөжин буурал” ТББ-тай хамтран зохион байгуулсан. Сургалтад сумдын 200 гаруй залуу малчид хамрагдсан

Зургаа мал аж ахуй, өвөлжилтийн талаар:

Аймгийн ургац хураалтын нэгдсэн дүн мэдээг гаргаж ХХААХҮЯ-нд хүргүүлсэн. Энэ онд аймгийн дүнгээр үр тариа 15875 га-д үүнээс улаан буудай 15500 га-д, арвай 240 га-д, овъёос 85 га, хөх тариа 50 га, мөн малын тэжээл 950, тосны ургамал 400 га, төмс 289 га, хүнсний ногоо 186 га, жимс- 105 га –д тус тус тариалах төлөвлөгөө өгөгдөж 19094 га-д үр тариа, үүнээс улаан буудай 18627 га, арвай 261 га, овъёос 126 га-д, мөн малын тэжээл 1357 га, тосны ургамал 300 га, төмс 295 га, хүнсний ногоо 204 га талбайд тариалсан нь улаан буудай 3127 га, арвай 21 га, овъёос 41 га, малын тэжээл 407 га, төмс 6 га, хүнсний ногоо 18 га-гаар тус тус нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Ургац хураалтын дүнгээр үр тариа 28385 тн, үүнээс улаан буудай 27957 тн, арвай 287 тн, овъёос 141 тн, мөн малын тэжээл 5097 тн, тосны ургамал 75 тн, төмс 2963 тн хүнсний ногоо 2471 тооныг тус тус хураан авлаа.

Түнэл сумын Талын хонхорт ногоо тариалж буй иргэдийн газрыг Бүрэнтогтох сумын Эрчим багт шилжүүлэх зорилгоор тухайн багийн нутагт төмс хүнсний ногоо тариалах боломжтой талбай, хөрс бүхий газрыг сонгох зорилгоор аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-ийн ахлах мэргэжилтэн Чинзориг, Мөрөн ногоочин Ж.Балдандорж, Цэнгэг ус компанийн захирал Даваадорж нарын хамт үзэж байршлын цэг тогтоосон.

ХХААХҮЯ-наас ирүүлсэн чиглэлийн дагуу 2022 оны хаврын тариалалтад нөөцөлсөн үрийн судалгааг сумдаас аж ахуйн нэгж иргэнээр нь гаргуулан авч нэгтгэн ГТБХЗГ-т хүргүүлсэн. Үр тарианы үйлдвэрлэл эрхлэгч 20 аж ахуйн нэгж 10 иргэнд 2022 оны тариалалтад зориулан 2199 тн буудайн үр нөөцөлсөн нь хаврын тариалалтад шаардлагатай улаан буудайн үрийн 86,6 хувийг бүрдүүлж нөөцөлсөн байна.

ХХААХҮЯ-наас зохион байгуулж буй “Өвлийн идэш” арга хэмжээнд сумдын малчид, иргэдийн бэлтгэсэн мах, сүү цагаан идээ зэрэг орон нутгийн мал аж ахуйн бүтээгдэхүүнийг оролцуулах ажлыг зохион байгууллаа. Энэхүү арга хэмжээнд 11 сумын 18 иргэн 86 тонн мах 16 тонн аарц, 6 тонн төрөл бүрийн цагаан идээтэй оролцлоо.

Монгол Улсад худалдаа хоол үйлдвэрлэлийн салбар үүсэж хөгжсөний түүхт 100 жилийн ойн хүрээнд хоол үйлдвэрлэлийн аж ахуйн нэгж байгууллагууд болон сонирхогч иргэдийн дунд өөрийн аймгийн үндэстэн ястнуудын хоолны өв соёлыг сэргээх, залуу хойч үед сурталчлах, уламжлалт хоолны ёс заншлыг сэргээн дэлгэрүүлэх орон нутгийн онцлог хоолыг илэрхийлэх зорилгоор Цаатан, Дархад, Халх, Урианхай, Хотгойд, Буриад үндэстний “Хоймор нутгийн зоог-2021” хоолны үзэсгэлэн гаргалаа. Энэ үйл ажиллагааг дэмжиж ЗДТГ-аас 1200,000 төгрөгний дэмжлэг үзүүллээ.

ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР:

Архитектур төлөвлөлтийн даалгавар: Ашиглагч байгууллагын ажлын даалгавар, захиалагчийн хүсэлтийн дагуу нийт 8 барилга байгууламжийн архитектур төлөвлөлтийн даалгаврыг боловсруулан аймгийн ерөнхий архитектороор батлуулан, холбогдох байгууллагад хүргүүлэн ажиллаж байна.

Зургийн даалгавар : Ашиглагч байгууллагын ажлын даалгавар, захиалагчийн хүсэлтийг үндэслэн нийт 19 барилга байгууламжийн засвар, шинэчлэлт, угсралтын ажлын зургийн даалгаврыг боловсруулан захиалагчаар батлуулж, холбогдох байгууллагад хүргүүлэв.

Техникийн нөхцөл олголт

Хууль, дүрмийн дагуу 2021 оны 10 сарын 15-наас дараа оны 4 сарын 15 хүртэл техникийн нөхцөл олгох үйл ажиллагаа зогссон.

Ажил эхлүүлэх зөвшөөрөл олгосон байдал

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 213 дугаар тогтоолоор батлагдсан “Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгох дүрэм”-ийн дагуу улс, орон нутгийн төсөв, хувийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэх 8 барилга, байгууламжид холбогдох баримт бичгийн бүрдлийг ханган ажил эхлэх зөвшөөрлийг олгосон байна.

Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжиж буй барилга байгууламжид захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн байдал:

Улс, орон нутгийн төсөв, хувийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй 14 /жагсаалтаар оруулах/ барилга, байгууламжийн ажлын явцад захиалагчийн хяналтын хийж, үүссэн зөрчил дутагдлыг арилгах зөвлөмж, үүрэг даалгавар өгч биелэлтийг хангуулан ажиллалаа. 2021 оны 11 сарын 10-наас Аймгийн мэргэжлийн хяналтын газраас ирүүлсэн 2/425 дугаартай ажил зогсоох тухай албан бичиг, ГХБХБГазрын даргын 2021.11.18-ны өдрийн 4/894 дугаартай албан бичгээр барилга байгууламжийн ажлыг 2022 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр хүртэл технологийн түр зогсолт хийхийг цахим болон цаасан хэлбэрээр аж ахуй нэгжид хүргэж ажлыг зогсоосон.

Аймгийн нийгмийн даатгалын хэлтсийн барилгын гадна фасадын ажил - 2 удаа хяналт тавьж ажилласан. дараах үүрэг даалгавар өгсөн. Үүнд: Зураг төсөвт барилгын 4 талыг хөөсөнцөр хавтангаар дулаалахаар тусгагдсан гүйцэтгэл дээр баруун тал хойд талыг хөөсөнцөр хавтангаар дулаалж зүүн тал, урд талыг хусаж эмульсдэх ажил хийгдэж байв. Зураг төсөлд 10см-н 20метр кубын хөөсөнцөр хавтанг 7см-н гарал үүсэл, тохирлын гэрчилгээгүй хөөсөнцөр хавтангаар гүйцэтгэж байсан.

Улсын комисс ажилласан барилга байгууламж:

“Хөвсгөл Геологи” ХК-ийн гүйцэтгэсэн Шинэ Мөрөн хорооллын 55 айлын орон сууцны IV блокын барилгыг байнгын ашиглалтад оруулах улсын комисс ажиллав. Их-Уул сумын төвийн хог хаягдлыг зайлуулах ажлыг хүлээж авах комисс ажиллав. Дараах барилга байгууламжийн ажилд комисс ажиллах захирамж гаргуулж байна. Үүнд:

- Цагаан-Уул сумын дотуур байрын засварын ажил
- Шинэ-Идэр сумын Ахмадын өргөөний барилга
- Тариалан сумын бэлчээрийн гүний худаг
- Тосонцэнгэл сумын бэлчээрийн гүний худаг
- Мөрөн сумын 1,3км авто замын засварын ажил
- Ренчинлхүмбэ сумын Жаргантын голын гүүрийн засвар
- Улаан-Уул сумын Багтагийн голын гүүрийн засвар
- Улаан-Уул сумын Өл тоомын давааны гүүрийн засварын ажил
- Мөрөн нисэх буудлын хүлээн авахын засварын ажил

Хот байгуулалтын кадастрын цахим систем:

Хот байгуулалтын мэдээллийн нэгдсэн санд сумын төвийн нийгмийн дэд бүтцийн болон бусад барилгыг бүртгэх ажлыг зохион байгуулж байна. Үүнд: Одоогийн байдлаар Төмөрбулаг, Арбулаг, Баянзүрх, Улаан-Уул, Цагааннуур, Рэнчинлхүмбэ, Ханх сумдыг хамруулан ажиллаж байна.

Барилгын материалын лаборатори:

Барилгын материалын лабораторид 2021 оны 11 сард 5 байгууллагаас ирүүлсэн 51 дээж хүлээн авч шинжилгээ хийж хариуг олгов.

Долоо. Байгаль орчин, аялал жуулчлал, уул уурхайн чиглэлээр

Аймгийн Засаг даргын удирдамжийн дагуу Алаг-Эрдэнэ, Хатгал, Рашаант, Их-Уул, Тосонцэнгэл сумдад ажиллаж мод бэлтгэлийн талбай тусгаарлалт, Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх, арга хэмжээний зардлын зарцуулалт, эрхийн бичиг олголтод хяналт шалгалт хийлээ.

2022 оны мод бэлтгэх дээд хязгаарыг батлуулах төслийг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээр хэлэлцүүлсэн.“Тэрбум мод” тарих хөдөлгөөнд 2022-2030 онд таригдах модны судалгааг гаргаж БОАЖЯаманд хүргүүлсэн.

ХЯНАСАН:

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ П.АРИНУБАТ

НЭГТГЭСЭН:

ТӨРИЙН ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН

МЭРГЭЖИЛТЭН

Б.БАЯРМАА